

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/213/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/159  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ОТГОН-ЭРДЭНЭ  
ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын төсвийн гүйцэтгэл 97.9 хувь буюу 5,125,573.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч тайлант жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдэл 107,633.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

#### Аудитын гол асуудал

Аудитаар зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн, байгууллагын газрын хэмжээг зөрүүтэй бүртгэсэн нийт 10,545.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын даргын Хөвсгөл аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг төлөвлөж, 94.3 хувьтай дүгнэгдсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5724040242

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/ төгрөгөөр /	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>86,320,163.84</b>	<b>11,837,243.84</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>11,891,500.00</b>	-
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>11,891,500.00</b>	-
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>11,891,500.00</b>	-
31213	Арилжааны банк дахь харилцах	11,891,500.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>68,430,200.00</b>	-
34600	Урьдчилж гарсан зардал	68,430,200.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,998,463.84</b>	<b>11,837,243.84</b>
<b>35300</b>	<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>		4,725,823.84
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>5,998,463.84</b>	<b>7,111,420.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,846,790.00	4,800,000.00
35420	Аж ахуйн материал	2,246,620.00	1,842,220.00
35430	Сэлбэг хэрэгсэл	20,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	1,885,053.84	469,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,069,643,438.87</b>	<b>1,072,312,592.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,069,643,438.87</b>	<b>1,072,312,592.84</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,033,815,438.75</b>	<b>1,037,086,592.64</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	908,579,919.15	908,579,919.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55,663,042.56	-69,578,803.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	107,600,000.00	81,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,466,666.77	-50,066,666.81
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	167,966,650.68	248,756,958.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68,224,822.35	-105,814,619.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,403,383.74	68,066,543.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,591,861.14	-54,668,616.63
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,400,000.00	5,400,000.00
39217	Ном	4,811,878.00	4,811,878.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>35,828,000.12</b>	<b>35,226,000.20</b>
39301	Програм хангамж	6,267,000.00	6,267,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,688,999.88	-5,290,999.80
39303	Бусад биет бус хөрөнгө	34,250,000.00	34,250,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,155,963,602.71</b>	<b>1,084,149,836.68</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,874,900.00</b>	<b>8,800,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,874,900.00</b>	<b>8,800,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	<b>8,800,000.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>8,800,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	8,800,000.00
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>11,874,900.00</b>	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	11,874,900.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,144,088,702.71</b>	<b>1,075,349,836.68</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,144,088,702.71</b>	<b>1,075,349,836.68</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	185,365,274.48	185,365,274.48
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	185,365,274.48	185,365,274.48
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>869,731,970.04</b>	<b>800,993,104.01</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	833,379,431.87	869,731,970.04
51220	Тайлант үеийн үр дүн	36,352,538.17	-68,738,866.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,991,458.19	88,991,458.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,155,963,602.71</b>	<b>1,084,149,836.68</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,885,823,144.00</b>	<b>5,778,201,098.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>277,480,344.00</b>	<b>410,878,852.06</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>277,480,344.00</b>	<b>410,878,852.06</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	43,306,903.00	61,620,531.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	234,173,441.00	349,258,320.83
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,608,342,800.00</b>	<b>5,367,322,246.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>5,415,373,400.00</b>	<b>5,233,206,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,415,373,400.00	5,233,206,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>192,969,400.00</b>	<b>134,115,646.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,940,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,627,680.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,325,120.00	110,987,246.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,600.00	14,188,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,849,470,605.83</b>	<b>5,846,903,809.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,849,470,605.83</b>	<b>5,846,903,809.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>887,597,879.96</b>	<b>1,438,125,672.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>331,292,773.94</b>	<b>588,708,860.29</b>
210101	Үндсэн цалин	219,807,265.11	312,997,901.83
210102	Нэмэгдэл	46,823,254.55	109,334,387.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,617,696.00	110,885,692.74
210104	Урамшуулал	30,044,558.28	55,490,877.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,161,245.92</b>	<b>75,453,929.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,780,492.70	51,463,036.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,385,495.89	6,052,569.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,678,157.13	4,819,995.67
210204	Ажилгүйдлийн даатгал	658,232.22	1,192,639.21
210205	Эрүүл мэндийн даатгал	6,658,867.98	11,925,688.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,287,243.87</b>	<b>47,874,608.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,857,869.62	2,250,576.43
210302	Түлш, халаалт	33,804,322.20	42,086,261.45
210303	Цэвэр, бохир ус	2,625,052.05	3,537,771.11
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,305,129.40</b>	<b>429,941,184.83</b>
210401	Бичиг хэрэг	1,946,260.00	3,139,440.00
210402	Тээвэр, шатахуун	8,547,037.20	5,237,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	991,142.20	1,072,884.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	64,450.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,756,240.00	2,344,820.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	417,926,590.83
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,421,500.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	3,421,500.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,629,000.00</b>	<b>2,006,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,629,000.00	2,006,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,171,961.00</b>	<b>2,849,086.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,171,961.00	542,086.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,307,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>444,329,025.83</b>	<b>291,291,602.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,155,234.00	8,309,130.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,745,460.00	204,067,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,428,331.83	78,915,222.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,961,872,725.87</b>	<b>4,408,778,137.01</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,805,222,977.00</b>	<b>4,298,874,118.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,759,287,023.00	2,341,832,076.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,029,445,954.00	1,956,720,542.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,490,000.00	321,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>156,649,748.87</b>	<b>109,904,019.01</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	154,840,713.27	107,633,423.01
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,809,035.60	2,270,596.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>36,352,538.17</b>	<b>-68,702,711.07</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>36,154.96</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	36,154.96
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>36,352,538.17</b>	<b>-68,738,866.03</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,623,261,400.00</b>	<b>5,355,447,346.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,623,261,400.00</b>	<b>5,355,447,346.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>5,415,373,400.00</b>	<b>5,233,206,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,415,373,400.00	5,233,206,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>207,888,000.00</b>	<b>122,240,746.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,940,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,627,680.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	146,200,020.00	110,987,246.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,060,300.00	2,313,500.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,611,369,900.00</b>	<b>5,347,338,846.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,611,369,900.00</b>	<b>5,347,338,846.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>649,497,174.13</b>	<b>938,560,708.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>331,292,773.94</b>	<b>588,708,861.00</b>
210101	Үндсэн цалин	219,807,265.11	312,997,902.54
210102	Нэмэгдэл	46,823,254.55	109,334,387.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,617,696.00	110,885,692.74
210104	Урамшуулал	30,044,558.28	55,490,877.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,161,245.92</b>	<b>75,453,929.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,780,492.70	51,463,036.46
210202	Тэтгэмжийн даатгал	3,385,495.89	6,052,569.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,678,157.13	4,819,995.69
210204	Ажилгүйдлийн даатгал	658,232.22	1,192,638.57
210205	Эрүүл мэндийн даатгал	6,658,867.98	11,925,688.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,287,243.87</b>	<b>47,874,608.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,857,869.62	2,250,576.43
210302	Түлш, халаалт	33,804,322.20	42,086,261.45
210303	Цэвэр, бохир ус	2,625,052.05	3,537,771.11

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,247,761.00</b>	<b>9,871,804.00</b>
210401	Бичиг хэрэг	2,139,050.00	1,800,050.00
210402	Тээвэр, шатахуун	6,537,908.80	5,237,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	991,142.20	1,072,884.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	64,450.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,515,210.00	1,541,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,385,700.00</b>	<b>60,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	60,000,000.00
210604	Урсгал засвар	3,385,700.00	0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,629,000.00</b>	<b>2,006,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,629,000.00	2,006,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,171,961.00</b>	<b>2,849,086.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,171,961.00	542,086.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,307,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>208,321,488.40</b>	<b>151,796,020.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,444,470.00	7,905,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	187,877,018.40	143,890,520.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,961,872,725.87</b>	<b>4,408,778,137.01</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,805,222,977.00</b>	<b>4,298,874,118.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,759,287,023.00	2,341,832,076.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,029,445,954.00	1,956,720,542.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,490,000.00	321,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>156,649,748.87</b>	<b>109,904,019.01</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	154,840,713.27	107,633,423.01
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,809,035.60	2,270,596.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>11,891,500.00</b>	<b>8,108,500.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>20,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>20,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>20,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	20,000,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>-20,000,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>11,891,500.00</b>	<b>-11,891,500.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,891,500.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,891,500.00	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>185,365,274.48</b>	<b>88,991,458.19</b>	<b>833,379,431.87</b>	<b>1,107,736,164.54</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,365,274.48	88,991,458.19	833,379,431.87	1,107,736,164.54
Тайлант үеийн үр дүн	-	-	36,352,538.17	36,352,538.17
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>185,365,274.48</b>	<b>88,991,458.19</b>	<b>869,731,970.04</b>	<b>1,144,088,702.71</b>
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>185,365,274.48</b>	<b>88,991,458.19</b>	<b>869,731,970.04</b>	<b>1,144,088,702.71</b>

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,365,274.48	88,991,458.19	869,731,970.04	1,144,088,702.71
Тайлант үеийн үр дүн	-	-	-68,738,866.03	-68,738,866.03
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>185,365,274.48</b>	<b>88,991,458.19</b>	<b>800,993,104.01</b>	<b>1,075,349,836.68</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,233,206,600.00</b>	<b>5,125,573,176.99</b>	<b>97.94</b>	<b>107,633,423.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,233,206,600.00</b>	<b>5,125,573,176.99</b>	<b>97.94</b>	<b>107,633,423.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>827,706,200.00</b>	<b>826,699,058.99</b>	<b>99.88</b>	<b>1,007,141.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>588,712,200.00</b>	<b>588,708,861.00</b>	<b>100.00</b>	<b>3,339.00</b>
210101	Үндсэн цалин	288,611,900.00	312,997,902.54	108.45	-24,386,002.54
210102	Нэмэгдэл	208,241,200.00	109,334,387.74	52.50	98,906,812.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396,000.00	110,885,692.74	332.03	-77,489,692.74
210104	Урамшуулал	58,463,100.00	55,490,877.98	94.92	2,972,222.02
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,146,900.00</b>	<b>75,453,929.00</b>	<b>99.09</b>	<b>692,971.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	53,006,900.00	51,463,036.46	97.09	1,543,863.54
210202	Тэтгэмжийн даатгал	5,785,000.00	6,052,569.62	104.63	-267,569.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,628,000.00	4,819,995.69	104.15	-191,995.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,157,000.00	1,192,638.57	103.08	-35,638.57
210205	Эрүүл мэндийн даатгал	11,570,000.00	11,925,688.66	103.07	-355,688.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,102,000.00</b>	<b>47,874,608.99</b>	<b>99.53</b>	<b>227,391.01</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,346,600.00	2,250,576.43	95.91	96,023.57
210302	Түлш, халаалт	42,086,300.00	42,086,261.45	100.00	38.55
210303	Цэвэр, бохир ус	3,669,100.00	3,537,771.11	96.42	131,328.89
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,848,900.00</b>	<b>9,836,804.00</b>	<b>99.88</b>	<b>12,096.00</b>
210401	Бичиг хэрэг	1,546,900.00	1,765,050.00	114.10	-218,150.00
210402	Тээвэр, шатахуун	5,233,400.00	5,237,450.00	100.08	-4,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199,300.00	1,072,884.00	89.46	126,416.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	440,000.00	220,000.00	50.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,429,300.00	1,541,420.00	107.84	-112,120.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>80,063,100.00</b>	<b>80,000,000.00</b>	<b>99.92</b>	<b>63,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000,000.00	80,000,000.00	100.00	0.00
210604	Урсгал засвар	63,100.00	0	0	63100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,012,100.00</b>	<b>2,006,400.00</b>	<b>99.72</b>	<b>5,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,012,100.00	2,006,400.00	99.72	5,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,849,900.00</b>	<b>2,849,086.00</b>	<b>99.97</b>	<b>814.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	542,900.00	542,086.00	99.85	814.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,307,000.00	2,307,000.00	100.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,971,100.00</b>	<b>19,969,370.00</b>	<b>99.99</b>	<b>1,730.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,575,900.00	4,575,500.00	99.99	400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,395,200.00	15,393,870.00	99.99	1,330.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,405,500,400.00</b>	<b>4,298,874,118.00</b>	<b>97.58</b>	<b>106,626,282.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,405,500,400.00</b>	<b>4,298,874,118.00</b>	<b>97.58</b>	<b>106,626,282.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,364,607,900.00	2,341,832,076.00	99.04	22,775,824.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад тэрөөс үзүүлэх дэмжлэг	2,040,571,000.00	1,956,720,542.00	95.89	83,850,458.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	321,500.00	100.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,233,206,600.00</b>	<b>5,125,573,176.99</b>	<b>97.94</b>	<b>107,633,423.01</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,233,206,600.00</b>	<b>5,125,573,176.99</b>	<b>97.94</b>	<b>107,633,423.01</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,233,206,600.00	5,125,573,176.99	97.94	107,633,423.01

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>122,240,746.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>122,240,746.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>119,970,150.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,000.00</b>
210401	Бичиг хэрэг	35,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>119,935,150.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,330,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,605,150.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,270,596.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,270,596.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	2,270,596.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>122,240,746.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>122,240,746.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,940,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,987,246.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,313,500.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 340,597.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс санхүүгийн тайлагналтай холбоотой 10,545.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 330,052.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,545.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 83,046.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 284,171.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 45,881.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, нийт 3 албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт 1:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 44 нэр төрлийн 54,000.7 мянган төгрөгийн 197 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

###### Илрүүлэлт 2:

Нягтлан бодох бүртгэлд тусгасан газрын хэмжээ 369 кв.м-ээр газрын гэрчилгээ, кадастрын зураг дээрх хэмжээнээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх;” заалттай нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэл болон газрын бичиг баримт дээрх холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, мэдээллийг зөрүүгүй болгох

##### 2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

2023 оны 8 сарын 17-ны өдрийн А/24 тоот тушаалаар О.Оюунтунгалагт нэг удаагийн тэтгэмж олгохдоо эдийн засгийн ангилал зөрүүлж, цалингийн зардлаас олгосон нь Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

**3. Газрын бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлд тусгасан газрын хэмжээ 369 кв.м-ээр газрын гэрчилгээ, кадастрын зураг дээрх хэмжээнээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй, " үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлд газрыг үнэн зөвөөр бүртгэж, залруулах.

**4. Байгууллагын дотоод хяналттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Байгууллагын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажлаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 4 ажил 60.0-80.0 хувийн гүйцэтгэлтэй, санхүүгийн үйл ажиллагаа болон шилэн дансанд хийх хяналтын ажил 50.0 хувийн гүйцэтгэлтэй бусад ажлууд хэрэгжээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцэхгүй, "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, тогтмолжуулах

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхын өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй.	1	-					1	-				
Эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	1320.0					1	1320.0				
Газрын бүртгэл бичиг баримтнаасаа зөрүүтэй	1	9225.0					1	9225.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>10545.0</b>					<b>3</b>	<b>10545.0</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлээгүй	1	284,171.6	1	284,171.6		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>284,171.6</b>	<b>1</b>	<b>284,171.6</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Хөвсгөлбулаг ХХК-ийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй	1	45,881.2	1	45,881.2		
Боловсролын ерөнхий хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй	1	-	1	-		
Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа хангалтгүй, төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хэрэгжээгүй	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>45,881.2</b>	<b>2</b>	<b>45,881.2</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>330,052.8</b>	<b>3</b>	<b>330,052.8</b>	<b>1</b>	<b>-</b>

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй						
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 29/А.2270439/20.А-2024/  
213/АА-СМ.А-НШЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 205,963,980 (хоёр зуун таван мянга есөн зуун жаран гурван мянга есөн зуун ная) төгрөгийн 22 мэдээлэл мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 78,207,600(далан найман сая хоёр зуун долоон мянга зургаан зуу)төгрөгийн 18 мэдээлэл мэдээлээгүй.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

### ШААРДАХ нь:

- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган, илэрсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
- Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Отгон-Эрдэнэ, нягтлан бодогч Г.Баасанням нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"ИХЭР МӨРӨН АУДИТ"ХХК  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР  
Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ байр, 3 давхар, 303 тоот

6724030101



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 30/А 2270439/ХӨА-2024/  
213/АА-СМА-ИШЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинээр ашиглалтад орсон спорт заалны тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээний гүйцэтгэгчээр 2020 онд шалгарсан Хөвсгөл булаг ХХК-ийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний санхүүжилтийг бүрэн олгож, гэрээний хугацаа дууссан боловч Рэнчинлхүмбэ, Арбулаг, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Улаан-Уул сумдын Ерөнхий боловсролын сургуулиуд болон Мөрөн сумын Титэм, Сод эрдэм сургуульд нийлүүлэх 48,881,200.0 /дөчин найман сая найман зуун наян нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийн тоног, төхөөрөмжийг нийлүүлээгүй байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/61 дүгээр тушаалаар баталсан "Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2.4.12-т "салбарын хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлага, хэрэгжилтийн явцын мэдээлэл нэгтгэх, хяналт тавих..." заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, 2024 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Отгон-Эрдэнэ, нягтлан бодогч Г.Баасанням нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724070110



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 31/АЭЭ70439/ХӨА-2024/  
213/АА-СНА-ШУЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Сайн арга зүй-сайн туршлага" сургалт, зөвлөн туслах үйлчилгээг Боловсрол, шинжлэх ухааны газрын албан хаагчид, сургуулийн захирлууд төлбөртэйгөөр гүйцэтгэсэн зөрчилд Боловсрол, шинжлэх ухааны газраас хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь тус газар Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1-т "Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;" 28.2.5-д "өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах;" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан "Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2.4.11-т "Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын уялдаа холбоог хангах, сайн туршлага, бүтээлч ажлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиг үүрэгтэй албан хаагчид төлбөртэй сургалт зохион байгуулсан зөрчилд хяналт тавьж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Отгон-Эрдэнэд даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК  
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724030113